



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 327

Улаанбаатар хот

“Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-ийг
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 12¹.9 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1.”Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-д дор дурдсан өөрчлөлтийг оруулснаар зөвшөөрсүгэй.

1.1.Дүрмийн 3.6 дахь заалтыг “Удирдах зөвлөл дараах тохиолдолд Холбооны гишүүний албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох саналыг Санхүүгийн зохицуулах хороонд уламжилна.”, дүрмийн 6.9.3 дахь заалтыг “Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрснөөр Холбооны гүйцэтгэх захирлыг томилж, чөлөөлөх;” гэж өөрчлөн найруулах;

1.2.Дүрмийн 6.9.6 дахь заалтын “гишүүнээс хасах” гэснийг, 3.2, 3.6.4 дэх заалтыг хасах.

2.”Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-ийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөл /Г.Хэрлэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Албан журмын даатгагчдын холбоо (цаашид “Холбоо” гэх) нь Монгол Улсад албан журмын даатгалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй даатгагчдыг нэгтгэсэн, гишүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, албан журмын даатгалыг төлөвшүүлэх ашгийн төлөө бус хуулийн этгээд байна.

1.2.Холбоо нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндсэн хууль, Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль болон албан журмын даатгалын бусад хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, энэ дүрмийн шаардлагад нийцүүлэн явуулна.

Хоёр.Холбооны зорилго, үйл ажиллагаа

2.1.Холбооны зорилго нь албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгагчдыг нэгтгэх, гишүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, гишүүд, даатгалын хохирогчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор хуульд заасан үйл ажиллагаа явуулахад оршино.

2.2.Холбоо нь энэхүү зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн явуулна:

2.2.1.Холбооны гишүүдийн албан журмын даатгалын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;

2.2.2.Холбооны гишүүдийг төрийн, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон бусад байгууллагын өмнө төлөөлөх;

2.2.3.хуульд заасны дагуу албан журмын даатгалын сан бүрдүүлэх, даатгалын сангаас хохирогчдод нөхөн төлбөр олгох, хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх;

2.2.4.албан журмын даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий даатгалын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, сүлжээг бий болгож, ашиглах;

2.2.5.албан журмын даатгалын шуурхай албыг ажиллуулах;

2.2.6.Холбооны гишүүдийн ашиг сонирхлыг хамгаалах, шүүхийн өмнө гишүүдийн эрх ашгийг хамгаалах;

2.2.7.Холбооны гишүүдэд албан журмын даатгал эрхлэх хүрээнд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, бусад үйлчилгээ үзүүлэх;

2.2.8.олон улсын албан журмын даатгалын зарчим, хэм хэмжээг нэвтрүүлэх;

2.2.9.албан журмын даатгалын чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах;

2.2.10.Холбооны үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, судалгаа шинжилгээний ажил явуулах, мэргэжлийн ном, сэтгүүл хэвлэн нийтлүүлэх;

2.2.11.албан журмын даатгалын салбарын мэдээлэл, статистик, хэлэлцүүлгийг сонирхогч, гишүүдэд танилцуулах;

2.2.12.албан журмын даатгалын семинар, зөвлөгөөн зохион байгуулах;

2.2.13.Холбооны үйл ажиллагааг нийтэд таниулах, даатгалын тохиолдлыг бууруулах, албан журмын даатгалын сургалт, сурталчилгаа явуулах;

2.2.14.албан журмын даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг жил бүр гаргах.

2.3.Холбооны нэр албан ёсоор АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО, англиар ASSOCIATION OF MANDATORY INSURERS гэнэ.

2.4.Холбоо нь дараах хаягаар оршино: Монгол Улс, Улаанбаатар хот.

2.5.Холбоо нь өөрийн эмблем, банкныбайгууллагад харилцах данстай байх бөгөөд тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2.6.Холбоо нь орон нутгийн хэмжээнд салбар байгуулж болно.

2.7.Холбоо нь 2011 оны ... сарын ... өдөр үүсгэн байгуулагдсан бөгөөд үйл ажиллагаа явуулах хугацаа нь хязгааргүй байна.

Гурав.Холбооны гишүүнчлэл

3.1.Санхүүгийн зохицуулах хорооноос албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нь Холбооны гишүүн байна.

3.2.Холбоонд гишүүнээр шинээр элсэх өргөдлөө даатгагч Удирдах зөвлөлд гаргана. **Удирдах зөвлөл тухайн даатгагчийн гишүүнчлэлийн асуудлаар хуралдаж шийдвэр гаргана.** [/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор нэмсэн/](#)

3.3.Холбооноос гишүүнд гишүүний батламжийг өгнө.

3.4.Холбоо нь гишүүдийн талаарх бүртгэлийг хөтлөнө.

3.5.Удирдах зөвлөл дараах тохиолдолд Холбооны гишүүний албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох саналыг Санхүүгийн зохицуулах хороонд уламжилна:

3.5.1.гишүүн нь албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх Холбооны болон бусад гишүүдийн ашиг сонирхолд бодит хохирол учруулсан;

3.5.2.гишүүн нь дүрмийн дагуу гаргасан Холбооны Удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлээгүй;

3.5.3.гишүүн нь гишүүний татвар болон хууль, журамд заасан бусад төлбөрийг тогтоосон хугацаанд нь бүрэн болон хэсэгчлэн төлөөгүй /жилд 2-оос дээш удаа/;

3.5.4.гишүүн нь дүрэмд заасан үүргээ биелүүлээгүй, Холбооноос зохион байгуулсан арга хэмжээнд 2-оос дээш удаа оролцоогүй.

3.6.Даатгагч нь Холбооны гишүүнээр элсэх үүргээ хэрэгжүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

3.6.1.Холбооноос тогтоосон стандартын дагуу гаргасан өргөдөл;

3.6.2.компанийн дүрмийн хуулбар;

3.6.3.компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.6.4.даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шийдвэр, гэрчилгээний хуулбар;

3.6.5.элсэлтийн хураамж төлсөн баримт;

3.6.6.компанийн хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн бүтцийн байдал;

3.6.7.компанийн гүйцэтгэх захирлыг томилсон эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.6.8.Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу гаргасан компанийн санхүүгийн тайлан, төлбөрийн чадварын үзүүлэлтийн тайлан, нөөц сангийн тайлан /сүүлийн жилийн болон улирлын байдлаар/;

3.6.9.компанийн салбарын мэдээлэл.

[/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор нэмсэн/](#)

Дөрөв.Холбооны гишүүний эрх, үүрэг

4.1.Холбооны гишүүний эрх:

4.1.1.Холбооны дүрэмд заасны дагуу Холбооноос үзүүлэх үйлчилгээг хүртэх, мэргэжлийн туслалцаа авах;

4.1.2.дүрэмд заасны дагуу Холбооны үйл ажиллагааны талаарх мэдээлэл авах;

4.1.3.Даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон Холбооноос зохион байгуулах арга хэмжээнд оролцох;

4.1.4.Холбооны үйл ажиллагаатай холбогдуулан удирдлагад санал, хүсэлт, гомдол гаргах.

4.2.Холбооны гишүүний үүрэг:

4.2.1.үйл ажиллагаандаа хууль, энэхүү дүрэм, холбогдох бусад журмыг сахих;

4.2.2.Холбоог санхүүгийн талаар дэмжиж, гишүүний татвараа цаг хугацаанд нь төлөх;

4.2.3.Холбооны дүрэм, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцох;

4.2.4.шаардлагатай статистик болон бусад мэдээллийг тухай бүр Холбоонд ирүүлэх;

4.2.5.Элсэлтийн хураамжийг Санхүүгийн зохицуулах хорооноос даатгагчид албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгогдсон өдрөөс хойш ажлын 7 хоногийн дотор, гишүүний татварыг тухайн жилийн 1 дүгээр сард багтаан төлөх.

[/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор нэмсэн/](#)

Тав.Холбооны бүтэц, зохион байгуулалт

5.1.Холбоо нь дараах бүтэцтэй байна:

- 5.1.1.Удирдах зөвлөл;
- 5.1.2.Ажлын алба.

Зургаа.Удирдах зөвлөл

6.1.Холбооны эрх барих дээд байгууллага нь Удирдах зөвлөл байна.

6.2.Удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг Санхүүгийн зохицуулах хороо томилно.

6.3.Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

6.4.Удирдах зөвлөлийн ээлжит хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулна.

6.5.Удирдах зөвлөлийн 1/3-ээс багагүй гишүүдийн шаардсанаар, эсхүл гүйцэтгэх захирлын бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн удирдах зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

6.6.Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи нь оролцсон бол хуралдааныг хүчинтэйд тооцож, хуралдоролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргана. Санал тэнцсэн тохиолдолдхуралдаан даргалагчийн саналыг үндэслэн шийдвэр гаргана. Холбооноос гишүүн хасах асуудлыг нийт гишүүдийн 2/3-ын саналаар шийдвэрлэнэ.

6.7.Удирдах зөвлөлийн хуралдааныг тэмдэглэлээр баталгаажуулах ба тэмдэглэлд хуралдаанаар хэлэлцсэн асуудал, баталсан шийдвэр, нууц санал хураалтыг тоогоор, ил санал хураалтыг нэрээр гаргасан дүн, сонирхлын зөрчилтэй холбогдсон тайлбар, гарах шийдвэрийн талаар зарчмын өөр саналтай гишүүний тайлбар зэргийг тэмдэглэнэ.

6.8.Удирдах зөвлөлийн гаргасан шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

6.9.Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхтэй:

- 6.9.1.Холбооны дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 6.9.2.Холбооны Ажлын албаны бүтэц, орон тоог батлах;

6.9.3.Холбооны Ажлын албаны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө болон төсвийг хэлэлцэж батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих, тайланг хэлэлцэх;
[/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 346 дугаар тогтоолоор хассан/](#)

6.9.3¹.Хорооноос бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн Холбооны гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх; [/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 279 дүгээр тогтоолоор нэмсэн/](#)

6.9.4.үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ажлын хэсэг байгуулах, шинжилгээний баг томилох;

6.9.5.шинээр гишүүн элсүүлэхасуудлыг шийдвэрлэх;

6.9.6.Удирдах зөвлөлийн дарга, гишүүдэд олгох урамшуулалын хэмжээг тогтоох;

6.9.7.Холбооны үйл ажиллагаагааг жил бүр Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнах;

6.9.8.Холбооны санхүүгийн хураангуй тайланг жил бүрийн эхний улиралд багтаан хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;

6.9.9.хуульд заасан бусад.

6.10.Удирдах зөвлөлийн дарга дараах бүрэн эрхтэй:

6.10.1.Холбоог дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

6.10.2.Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хуралдааныг товлох, даргалах;

6.10.3.Удирдах зөвлөлийн гишүүний ажил үүргийг хуваарилж, гүйцэтгэлд нь хяналт тавих.

6.11.Холбооны Удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг дараах үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлөх талаар Удирдах зөвлөл Санхүүгийн зохицуулах хороонд уламжилна:

6.11.1.эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

6.11.2.үүрэгт ажлаасаа чөлөөлүүлэхийг хүсэж өөрөө өргөдөл гаргасан;

6.11.3.төлөөлж буй байгууллагаас чөлөөлөгдсөн буюу халагдсан;

6.11.4.үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй.

Долоо.Ажлын алба

7.1.Холбоо нь Ажлын албатай байна.

7.2.Ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулах чиг үүргийг холбооны гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, Удирдах зөвлөлөөс өгсөн үүргийн биелэлтийг хангана. **Албан журмын даатгагчдын холбооны гүйцэтгэх захирлыг Санхүүгийн зохицуулах хороо томилж, чөлөөлнө.** [/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 346 дугаар тогтоолоор нэмсэн/](#)

~~**Холбооны гүйцэтгэх захирлыг Удирдах зөвлөлийн саналыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо томилж, чөлөөлнө.**~~ [/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 279 дугаар тогтоолоор хассан/](#)

7.3.Ажлын алба нь дараах алба, сантай байна:

7.3.1.албан журмын даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий даатгалын мэдээллийн нэгдсэн сан;

7.3.2.даатгуулагч, даатгагч, хохирогч, иргэдээс даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авч, даатгалын тохиолдлыг үнэн зөв, шуурхай тодорхойлох боломжийг даатгагч, даатгуулагч, хохирогчид бүрдүүлэх чиг үүрэг бүхий шуурхай алба;

7.3.3.албан журмын даатгалын сан.

7.4.Ажлын алба ньбайнгын орон тоотой ажилтнуудтай байх ба гүйцэтгэх захирлын шийдвэрээр томилно.

7.5.Удирдах зөвлөлийг төлөөлж Удирдах зөвлөлийн дарга гүйцэтгэх захиралтай холбогдох хууль, тогтоомжийн дагуу гэрээ байгуулж ажиллахбөгөөд түүнд гүйцэтгэх захирлын эрх, үүргийг нарийвчлан тусгана.

7.6.Гүйцэтгэх захирал нь ажилтнуудтай холбогдох хууль, тогтоомжийн дагуу гэрээ байгуулж ажиллана.

7.7.Гүйцэтгэх захирал нь албан журмын даатгалын сан, даатгалын мэдээллийн сан, шуурхай албаны даргыг Удирдах зөвлөлтэй зөвшилцсөний дагуу томилно.

7.8. Гүйцэтгэх захирал нь дараах шаардлагыг хангасан байна:

7.8.1. Зээлийн батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй;

7.8.2. Ял шийтгэлгүй;

7.8.3. Ёс зүйн болон захиргааны зөрчлийн улмаас аливаа шийтгэл хүлээж хариуцлага тооцогдож байгаагүй, энэхүү үндэслэлээр албан тушаалаас чөлөөлөгдөөгүй байх;

7.8.4. Санхүү, эдийн засаг, хууль зүйн, инженерийн дээд боловсролтой, эдийн засгийн салбарт 5-аас доошгүй жил удирдах албан тушаалтнаар ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай.

[/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 358 дугаар тогтоолоор нэмсэн/](#)

7.9. Гүйцэтгэх захирал дор дурдсан эрх, үүрэгтэй:

7.9.1. Удирдах зөвлөлийн өмнө Холбооны үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жилд нэгээс доошгүй удаа ажлын үр дүн, гэрээний үүргийн биелэлтийг тайлагнан дүгнүүлэх;

7.9.2. Холбооны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг хуульд заасан хугацаанд гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг хариуцах;

7.9.3. Тухайн жилийн Холбооны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, Удирдах зөвлөлд танилцуулж батлуулах;

7.9.4. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн Удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

7.9.5. Холбооны эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан Ажлын албыг удирдах;

7.9.6. Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээ, мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх;

7.9.7. Удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах,

ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;

7.9.8. Гүйцэтгэх захирал нь өөр бусад хуулийн этгээдийн удирдлагад давхар ажиллахгүй байх.

[/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 358 дугаар тогтоолоор нэмсэн/](#)

Найм.Санхүүжилт

8.1.Холбооны хөрөнгө дараахь үндсэн эх үүсвэрээс бүрдэнэ:

8.1.1.үүсгэн байгуулагчдаас шилжүүлсэн хөрөнгө;

8.1.2.элсэлтийн хураамж, гишүүний татвар болон бусад төлбөр;

8.1.3.зээл, тусламж, хандив;

8.1.4.хуулиар зөвшөөрсөн бусад эх үүсвэр.

8.2.Холбооны гишүүний элсэлтийн хураамж болон дараа жилд төлөх татварын хэмжээг жил бүрийн 12 дугаар сард багтаан Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн тогтооно. *[/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор нэмсэн/](#)*

8.3.Холбоо нь үйл ажиллагаанаас олсон орлогоо гишүүддээ хуваарилахгүй, Холбооны мөнгөн хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэрийг зөвхөн Холбооны зорилгод нийцсэн хуульд заасан үйл ажиллагаанд зарцуулна.

8.4.Албан журмын даатгалын сангуудыг хэлбэр тус бүрээр тусад нь бүртгэж, бие даасан данстай байна.

8.5.Холбоо нь даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг жил бүр гаргах бөгөөд уг сангийн үйл ажиллагаа, тайланд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина.

Ес.Холбоог өөрчлөн байгуулах, татан буулгах

9.1.Холбоог өөрчлөн байгуулах асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

9.2.Холбоог татан буулгахаар шийдвэрлэсэн бол Удирдах зөвлөл нь Татан буулгах комиссийг томилох бөгөөд түүний бүрэлдэхүүнд нь Удирдах зөвлөл, Ажлын албаны төлөөллийг оролцуулна.

9.3.Холбоог татан буулгасны дараа түүний төлөх бүх өр төлбөрийг барагдуулсны дараагаар үлдсэн хөрөнгийг татан буулгах комиссийн шийдвэрээр ижил төстэй зорилго бүхий төрийн бус байгууллагад шилжүүлэх, хэрэв тийм төрийн бус байгууллага байхгүй бол тус Холбооны зорилгод нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна.

Арав.Бусад

10.1.Санхүүгийн зохицуулах хороо нь Холбооны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, зааврыг баталж, уг Холбооны үйл ажиллагаанд хяналт тавина.